

БАТЛАВ
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГА М.БАЯРСАЙХАН

2024 оны 06 дугаар сарын 13

ХУДГИЙН ЦООНОГ ГАРГУУЛАХ
ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

Байршил: Өмнөговь аймгийн Ханхонгор сумын Өгөөмөр багийн нутаг Гаагийн шанд, Баянгийн их бууц, Жимгэр, Ингэний ферм гэсэн 4 газар, Жаргалант багийн нутаг Сүүжийн хадана бууц, Мандах багийн нутаг Дарийн шанд, Хондот багийн нутаг Гашууны хонхор нийт 7 газарт өрөм гаргах.

1. Ажлын тодорхойлолт: Бэлчээр усжуулалтанд зориулж худгийн цооног шинээр гаргана.
 - 1.1 Худгийн цооног гаргахаас өмнөх ба дараах үеийн гэрэл зургийг нэг цэгээс авч худгийн солбилцолыг нарийвчлан тодорхойлсон байна.
 - 1.2 Худгийн цооног өрөмдөх, тоног төхөөрөмж суурилуулах ажилд тавих техникийн шаардлага MNS 6088:2010 стандартын дагуу худагт өрөмдлөг, шавхалт, туршилтийн ажлыг явуулах, худгийн усны шахуурга, цахилгаан үүсгүүрийг сонгон суурилуулах ажлыг гүйцэтгэнэ.
 - 1.3 Монгол Улсын Хөдөө Аж Ахуйн сайд, Байгаль орчны сайд, Сангийн сайдын 2005 оны 7 дугаар сарын 15-ны өдрийн 101, 189, 194 дүгээр хамтарсан тушаалаар батлагдсан "Инженерийн хийцтэй худаг, уст цэгийг сэргээн засварлах, шинээр гаргах, санхүүжүүлэх, эзэмших, ашиглах нийтлэг журам"-ыг мөрдөнө. Үүнд:
 - Ажлын иж бүрдэлд цооног өрөмдөх, бэхэлгээ, суултын яндан, шүүр суурилуулах, цооногийг цэвэрлэх, шавхалт туршилтын ажил хийх, ус шахуурга, цахилгаан үүсгүүр суурилуулах зэрэг ажлыг багтаана.
 - Шинээр өрөмдөхийн өмнө хайгуулын ажлаар устай эсэхийг тогтоосон акт үйлдэнэ. Ус багатай бол өрөмдөх шаардлагагүй, дахин хайгуул хийнэ.
 - Худгийн цооног өрөмдлөгийн ажлын талаархи мэдээллийг өрөмдлөгийн ажлын журналд тэмдэглэнэ. Өрөмдлөгийн ажлыг дууссаны дараа шавхалтын ажлыг заавал хийж, шавхалтын ажлын журналыг дэлгэрэнгүй үйлдэнэ.
 - Худгийн техникийн паспортыг хөтөлж, аймгийн БОАЖГазраар баталгаажуулан, сумын Засаг даргын тамгын газарт хүлээлгэн өгнө.
 - Уст цэгийг шинээр гаргаж хүлээлгэн өгсөн тухай Өмнөговь аймгийн ажлын хэсгийн акт №2"-ыг, уст цэгийг шинээр гаргасан далд ажлын тухай Өмнөговь аймгийн ажлын хэсгийн акт №3", Тоног төхөөрөмж хүлээлгэн өгсөн актын хамт үйлдэж суманд хүлээлгэн өгнө.
 - Худгийн усны шахуурга дараах шаардлагыг хангасан байна. Үүнд Гарал үүслийн гэрчилгээтэй, үйлдвэрлэгчийн нэр, хаяг, барааны олон улсын гэрчилгээтэй байх.
 - 1.4 Усны химийн болон бактериологийн шинжилгээг мэргэжлийн байгууллагаар хийлгэж хариуг худгийн паспортод хавсаргасан байх.
 - 1.5 Худгийн цооног өрөмдөх зөвшөөрөлийг худгийн ажил эхлэхээс өмнө аймгийн БОАЖГазраас авна. /Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын тогтоолоор 1 цооног өрөмдөх зөвшөөрөл 240,000 төгрөгийг Ханхонгор сумын ЗДТГ-н дансанд төвлөрүүлнэ/

- 1.6 Техникийн тодорхойлолт шаардлагад заасан хэсэг тус бүрээр саналаа тодорхой тайлбарын хамт, цооногийн хийц зохиомж, бүдүүвч, цооногийн гүн, суултын болон шүүр яндангийн голч зэрэг үзүүлэлтийг танилцуулгын хамт ирүүлнэ.

ХУДГИЙН ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ БОЛОН ШААРДЛАГА

№	Үзүүлэлтүүд	Тендерт оролцогчийн санал
2.	Худгийн цооног өрөмдөх, тоног төхөөрөмж суурилуулах ажилд тавигдах техникийн шаардлага MNS 6088:2010 стандартыг мөрдөнө.	
2.1	Цооног өрөмдөх, цооногийг тоноглох	
2.2	Геофизикийн хайгуул судалгаа хийж, худгийн байршлыг эцэслэн тогтоох	
2.3	Цооногийг 219 мм-ээс багагүй голчтой өрөмдөх, бэхэлгээ, суултын болон шүүр янданг суулгана. Өрөмдлөгийн үед хурдас чулуулаг өөрчлөгдөх тутамд хөрсний дээжийг авна. Цохилтод өрмөөр өрөмдсөн, хадан хөрстэй цооногийн нийт гүнд суултын янданг заавал суурилуулна.	
2.4	Цооногийн ашиглалтын ундарга: 1л/сек-ээс багагүй хүчин чадалтай байна.	
2.5	Цооногийн гүн нь 100-120 м байна.	
2.6	Суултын яндангийн материал нь ган, ундны усанд хэрэглэхэд зөвшөөрөгдсөн хуванцар хоолой, 168мм-ээс багагүй голчтой янданг ашиглана.	
2.7	Шүүрийн яндан нь зориулалтын байх, материал нь ган, ундны усанд хэрэглэхэд зөвшөөрөгдсөн хуванцар хоолой, 168 мм-ээс багагүй голчтой байна.	
2.8	Ус өргөх яндангийн диаметр 32 мм-ээс багагүй, материал нь төмөр болон ундны усанд хэрэглэхэд зөвшөөрөгдсөн хуванцар хоолой ISO /хүйтний улиралд тэсвэртэй/ стандартын шаардлага хангасан байна	
2.9	Ус шүүх хайрга нь шигшсэн, мөлгөр хэлбэртэй, тоосонцор хольцгүй, мөхлөгийн хэмжээ 9 мм-ээс томгүй байна.	
2.10	Тунгаагуурын гүн: 2м-ээс багагүй	
2.11	Цооногт шавхалт хийх хугацаа: 24 цагаас багагүй, уст үеийн хүчин чадлыг тогтоох шавхалтыг шаталсан болон тогтмол ундаргатай шавхалтаар хийнэ.	
2.12	Усны чанарын шинжилгээг мэргэжлийн байгууллагаар хийлгэх	
2.13	Худгийн цооногийг түр хугацааны тагаар тоноглож хүлээлгэн өгөх	
3.	Худгийн ажлыг дуусгаж хүлээлгэж өгөх	
3.1	Талбайг цэвэрлэх /өрөмдлөгийн шлам, болон ахуйн хог хаягдал гэх мэт/	
3.2	Акт материалууд, техникийн паспорт бэлтгэнэ, хүлээлгэн өгнө.	